



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 640

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 43,845,400.00 (дөчин гурван сая найман зуун дөчин таван мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зардлыг хассан дүнгээр зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;


2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ГАНБАТ

Б.ГАВАА

0002657

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
640 дугаар тогтоолын хавсралт

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ								
1	УАЗ-31512/31514, 7484ӨВА, суудлын, 70564786.60014198	2007	98430	13 431 000.00	13 431 000.00	-		500 000.00
	ХЭСГИЙН ДҮН			13 431 000.00	13 431 000.00	-		500 000.00
ХОВД АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ								
2	УАЗ-22069-033, 2893ХОА, суудлын, 80438676.70902413	2007	125421	30 414 400.00	30 414 400.00	-		500 000.00
	ХЭСГИЙН ДҮН			30 414 400.00	30 414 400.00	-		500 000.00
	НИЙТ ДҮН	-	-	43,845,400.00 (дөчин гурван сая найман зуун дөчин таван мянга дөрвөн зуун)	43,845,400.00 (дөчин гурван сая найман зуун дөчин таван мянга дөрвөн зуун)	-	-	1,000,000.00 (нэг сая)